

## ЗАЛУУЧУУДЫН ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТЛАХ БОДЛОГО

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Залуучуудын талаар төрөөс баримтлах бодлого нь Монгол залуу хүн өөрийн ёс суртахуун, авьяас билэг, оюуны болон бие бялдрын чадвараа нийгэмдээ эергээр хөгжүүлэх, уламжлал, ёс заншлаа өвлөн авах боломжийг бүрдүүлэх, боловсрол, эрүүл мэндийн хүртээмжтэй үйлчилгээгээр хангагдах, хөдөлмөрлөх, амьдрах чанартай орчныг бүрдүүлэхэд чиглэгдсэн нийгэм, эдийн засаг, улс төр, эрх зүйн нөхцөлүүдийг тэдний өөрсдийн оролцоотойгоор бүрдүүлэх замаар хэрэгжинэ.

1.2. Энэхүү бодлогыг боловсруулах эрх зүйн үндэслэл нь Монгол Улсын Үндсэн Хууль, Гэр бүлийн тухай хууль, Жендерийн тэгш байдлыг хангах тухай хууль, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Хүний хөгжлийн сангийн тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль, Боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчийн нийгмийн баталгааны тухай хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, “Монгол Улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого”, “Монгол Улсын төрөөс хүн амын талаар баримтлах бодлого”, “Монгол Улсын Төрөөс гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлого”, “Төрөөс орон сууцны талаар баримтлах бодлого”, “Биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого”, “Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого”, “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”, Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Засгийн газар болон төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллагаас залуучуудын талаар хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрөөс бүрдэнэ. Хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжоор залуучуудтай холбоотой нийтлэг асуудлуудыг нийгмийн бусад насны бүлгүүдтэй ижил түвшинд зохицуулсан боловч залуучуудын онцлог, хөгжлийн хэрэгцээ, тулгарч буй асуудлуудад тусгайлан зориулсан бодлогын чиглэл тодорхойгүй байгаа нь энэхүү бодлогын хэрэгцээ, шаардлагыг үндэслэж байна.

### Хоёр. Нэр томъёоны тодорхойлолт

2.1. Энэхүү баримт бичигт хэрэглэгдсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

2.2.1 “Залуу үе” гэдэгт арван таваас хорин есөн настай Монгол Улсын иргэн, харьяалалгүй хүнийг;

- 2.2.2 “Өсвөр үе” гэдэгт арваас арван есөн настай Монгол Улсын иргэн, харьяалалгүй хүнийг;
- 2.2.3 “Залуучууд” гэдэгт өсвөр болон залуу үеийг;
- 2.2.4 “Залуу гэр бүл” гэдэгт аль нэг гишүүн нь эсхүл нь эхнэр, нөхөр хоёулаа гучин нас хүрээгүй гэр бүлийг;
- 2.2.5 “Залуу эцэг, эх” гэдэгт гучин нас хүрээгүй эх, эцгийг;
- 2.2.6 “Нийгмийн дэмжлэг хэрэгтэй хэсэг” гэдэгт хөгжлийн бэрхшээлтэй, ядуу, орон гэргүй, бусад хэлбэрээр нийгмээс тусгай халамж анхаарал шаардахуйц нөхцөл байдалд байгаа залуу үеийг;
- 2.2.7 “Залуучуудын хөтөлбөр” гэж төрөөс залуучуудын талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн зорилтот ажлуудын үе шат, хүрэх түвшинг тодорхойлсон, түүнд оролцогч талуудын үйл ажиллагааны уялдаа, санхүүжилтийн зарчим, төрөл, хөтөлбөрийн ийг тодорхойлсон баримт бичгийг;
- 2.2.8 “Залуучуудын салбар” гэдэгт залуучуудын хөгжлийг дэмжих үндсэн зорилго, чиг үүрэг бүхий төрийн болон төрийн бус байгууллага, өдөр тутмын үйл ажиллагаагаараа залуучуудад үйлчилдэг аж ахуйн нэгжийг.

#### Гурав. Бодлогын зорилго, зорилтууд

- 3.1. Залуучуудын талаар баримтлах бодлогын зорилго нь өсвөр, залуу үеийг хөгжүүлэх, тэдний аливаа эрхийг хамгаалах, хүмүүжих, суралцах, хөдөлмөрлөх таатай нөхцөлийг бүрдүүлж, амьдралын чанарыг дээшлүүлэхэд оршино.
- 3.2. Энэхүү бодлого нь дараах зорилтуудын хүрээнд хэрэгжинэ. Үүнд:
  - 3.2.1. Залуучуудын эрх бүх түвшинд хамгаалагдах нөхцөлийг бүрдүүлэх;
  - 3.2.2. Боловсролыг чанартай, хүртээмжтэй байлгах;
  - 3.2.3. Залуучуудын онцлог, хэрэгцээнд нийцсэн, чанартай эрүүл мэндийн үйлчилгээг бий болгох;
  - 3.2.4. Залуучуудын хөдөлмөрийн таатай нөхцөлийг бүрдүүлэх;
  - 3.2.5. Залуучуудын орон байрны хэрэгцээг хангах төрөл бүрийн шийдлүүдийг бий болгоход дэмжлэг үзүүлэх;
  - 3.2.6. Нийгэм дэх залуучуудын эерэг дүр төрхийг бий болгох;
  - 3.2.7. Залуучуудын оролцоог дэмжих механизмыг бий болгох;
  - 3.2.8. Нийгмийн дэмжлэг хэрэгтэй залуучуудад зохистой арга, хэлбэрээр хүрч ажиллах;
  - 3.2.9. Залуучуудын байгууллага, залуучууд судлалыг тууштай хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

#### Дөрөв. Бодлогын тулгуур зарчмууд

- 4.1. Залуучуудын бодлогыг хэрэгжүүлэх талаар олон улсын хэмжээнд дараах зарчмуудыг дэвшүүлж байна. Үүнд: (а) хүний эрхэд суурилсан байх; (б) бүгдийг хамруулах; (в) оролцоог дэмжих; (г) жендерийн баримжаатай байх; (д) иж бүрэн хандах; (е) мэдлэг, нотолгоо баримтад үндэслэж байх; (ё) санхүүжилтийн үр ашигтай төлөвлөлт, зарцуулалт;

(ж) хариуцлагатай тайлагнал. Эдгээр зарчмуудыг 2014 онд НҮБ-аас Азербайжан Улсын Баку хотноо зохион байгуулсан Дэлхийн Залуучуудын Бодлогын Анхдугаар Форумаар дэвшүүлснийг анхаарч үзнэ.

4.2. Төрөөс залуучуудын талаар явуулж буй үйл ажиллагаанд дараах зарчмуудыг баримтлан ажиллана. Үүнд:

- 4.2.1. Залуучуудыг эх орныхоо өнөө ба ирээдүйн хөгжилд чухал үүрэгтэй бөгөөд нийгэм дэх эерэг хүч гэж үнэлнэ.
- 4.2.2. Залуучуудын төрөлхийн болон үндэсний, олон улсын эрх зүйн хүрээн дэх аливаа эрхийг нь хүндэтгэн эдлүүлэхэд төрийн бодлого чиглэгдэнэ.
- 4.2.3. Залуучуудыг иргэний харьяалал, нас, хүйс, яс үндэс, шашин шүтлэг, итгэл үнэмшил, оюуны болоод бие махбодын чадвар, бэлгийн чиг хандлага, боловсролын түвшин, хувь хүний бодитоор ба бусдад ойлгогдох онцлогоос хамаарах аливаа ялгаварлал, гадуурхлаас ангид байлгана.
- 4.2.4. Залуучууд хувийн болон нийгмийн амьдралын бүхий л хүрээнд өөрсдийн хэрэгцээ шаардлага, хүсэл эрмэлзлэлийн үндсэн дээр адил тэгш боломжоор хангагдана.
- 4.2.5. Залуучуудыг өөрсдийн амьдралд нь нөлөө үзүүлэхүйц, чухал ач холбогдолтой бодлого, шийдвэр гаргах, хэрэгжүүлэх, тэдгээр үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөхөд оролцуулна.
- 4.2.6. Залуучуудын бодлогын төлөвлөлт, хэрэгжүүлэлт, тэдгээрийн дүн шинжилгээ нь нотолгоо баримтад үндэслэсэн, залуучуудын бодит хэрэгцээ, олон улсын стандарт, тэргүүн туршлагад тулгуурласан, салбар хоорондын уялдааг цогцоор нь хангасан байна.
- 4.2.7. Залуучуудын бодлого нь тууштай, залгамж холбоотой байх бөгөөд энэ чанар нь Улсын Их Хурал дахь олонх, цөөнхийн харьцаанд өөрчлөлт орох, Засгийн газар шинээр байгуулагдах, төрийн захиргааны тогтолцоо, бүтцэд өөрчлөлт оруулахад орхигдох ёсгүй.

#### Тав. Бодлогын хэрэгжих хугацаа

- 5.1. Төрөөс залуучуудын талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх эхний үе шат нь 2015-2025 оныг хүртэл хугацааг хамарна.
- 5.2. Бодлогын хэрэгжилтийг хануулах залуучуудын хөтөлбөрийг боловсруулахдаа энэ баримт бичгийн 5.1-д заасан хугацааг тодорхой үе шатуудад хувааж болно.

#### Зургаа. Залуучуудын эрх бүх түвшинд хамгаалагдах нөхцөлийг бүрдүүлэх чиглэл

6.1. Залуучуудын эрхийг хамгаалах асуудлаарх олон улсын хамтын ажиллагаанд идэвхтэй байр суурь баримталж, залуучуудын эрхийн тухай хоёр талын болон олон талын гэрээ, конвенц, зарчмуудад нэгдэх, тэдгээрээр хүлээсэн үүргээ гэрээний бусад талууд, олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө шударгаар биелүүлж ажиллана.

6.2. Хүний эрх, хүүхэд, залуучуудын эрхийн талаар соёрхон баталсан буюу нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцыг үндэсний хууль тогтоомжийн нэгэн адил сахин

биелүүлж, тэдгээрийг хэвлэн нийтлэх, шийдвэр гаргахад хэрэглэх ажлыг тогтмол зохион байгуулна.

6.3. Үндэсний хууль тогтоомжийг энэ баримт бичгийн 7.2 –т заасан олон улсын эрх зүйн баримт бичгүүдтэй уялдуулах ажлыг тухай бүр хэрэгжүүлнэ.

6.4. Залуу хүний эрхэмсэг оршихуйг хүндэтгэсэн залуучуудтай харилцах харилцааны стандартыг бий болгоно.

6.5. Залуучуудын бодлого, эрхийн боловсролыг залуучуудад төдийгүй ажил хариуцсан бүх түвшний төрийн албан хаагч нарт системтэйгээр олгох замаар залуучуудын эрхийн зөрчил, тулгамдсан сорилтуудад идэвхтэй, зохистой хариу үйлдэл үзүүлдэг тогтолцоог бий болгоно.

6.6. Нийгэмд эзэлж буй байр сууриасаа хамаарч эдлэх ёстой эрхээ эдэлж чадахгүй байгаа залуу хүмүүст дэмжлэг үзүүлэх санал санаачилгуудыг төрөөс дэмжиж ажиллана.

6.7. Залуучуудад чиглэсэн бүхий л үйл ажиллагаанд тэдний оролцооны эрхийг хангана.

#### Долоо. Боловсролыг чанартай, хүртээмжтэй байлгах чиглэл

7.1. Хот, хөдөө дахь ерөнхий боловсролын чанарын ялгааг арилгах, сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох, сурах бичиг, багшийн хөгжил, сургалтын чанарын үнэлгээ, мониторинг, хөрөнгө оруулалтыг цогцоор нь боловсролын талаарх хууль тогтоомж, салбарын бодлогын хүрээнд хэрэгжүүлнэ.

7.2. Суурь болон ерөнхий боловсролыг газар зүйн байрлал, хүйс, яс үндэс, нийгмийн бусад байдлаас үл хамаарахуйц хүртээмжтэй байлгахад тууштай анхаарал хандуулж шийдвэрлэнэ.

7.3. Бүх шатны сургуулийн суурь зорилт нь залуучуудад Монголын нийгмийн үнэт зүйлсийн баримжаа, иргэний боловсрол олгох, техникийн болон мэргэжлийн чиг баримжаа олж авах, авьяасаа нээх, нөхөн үржихүйн болон эрүүл мэндийн суурь боловсрол авах идэвхтэй орчин байх явдал болно.

7.4. Бүх шатны сургуульд хөгжлийн бэрхшээлтэй иргэд элсэн суралцах, нэвтрэх, суралцах, судалгаа хийх, номын сангаар үйлчлүүлэх зэрэг бүх нөхцөл шаардлагыг хангуулна.

7.5. Мэргэжлийн боловсролыг төрөөс түлхүү дэмжих бодлогыг тууштай барина.

7.6. Албан боловсролын тогтолцооны шатлалыг олон улсын жишгээр олон зэрэглэлт сертификат, нэгдсэн кредитэд оруулах замаар залуучууд сурах болон хөдөлмөрлөх хугацаагаа амьдралын хэрэгцээ, санхүүгийн боломжийн хүрээнд шийдвэрлэх боломжийг бүрдүүлнэ.

7.7. Их, дээр сургуулийн суралцагч нь үндсэн мэргэжил ба дэд мэргэжил (хос мэргэжил) –ээр суралцах боломжийг бүрдүүлэх замаар хөрвөх чадвараа нэмэгдүүлэх боломж олгоно. (Жишээлбэл, үндсэн мэргэжил “сэтгүүл зүй”, дэд мэргэжил “байгаль хамгаалал” гэх мэт)

7.8. Их, дээд сургуулиуд ба төгсөгчдийн хоорондын эргэх холбоог хангуулах, төгсөгчдийг хөдөлмөрийн зах зээлд байршиж буй үзүүлэлтийг бодитойгоор тооцсон, шударга шалгуур бүхий хөндлөнгийн рейтингийн системийг нэвтрүүлэх замаар шударга өрсөлдөөнийг бий болгоно.

#### Найм. Залуучуудын онцлог, хэрэгцээнд нийцсэн чанартай

## эрүүл мэндийн үйлчилгээг бий болгох чиглэл

- 8.1. Залуучуудын зориулсан эрүүл мэндийн үйлчилгээ, мэргэшсэн хүний нөөцийн хөгжлийн талаар тухайлсан салбарын бодлогыг холбогдох судалгаа шинжилгээнд тулгуурлан боловсруулж, хэрэгжүүлнэ.
- 8.2. Залуучууд, залуу гэр бүлд эрүүл мэндийн үзлэг, үйлчилгээ, урьдчилан сэргийлэх мэдлэг, мэдээлэл хүргэхдээ нь залуу хүний сэтгэхүй, эмзэг байдал зэрэг онцлогийг харгалзаж, харилцааны сэтгэл зүйн ур чадвар, арга зүйд тулгуурлана.
- 8.3. Бүх нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх бодлогын хүрээнд залуучуудын чөлөөт цаг өнгөрөөх, бие бялдрыг чийрэгжүүлэхэд төрөөс онцгой анхаарч биеийн тамир, спортын цогцолбор, цэцэрлэгт хүрээлэн байгуулах, техник хэрэгслийг үйлдвэрлэх, импортлоход татварын хөнгөлөлт үзүүлэх эрх зүйн орчныг бий болгоно.
- 8.4. Нийслэлд залуучууд, оюутнуудад үйлчлэх дагнасан поликлиник байгуулна.

## Ес. Залуучуудын хөдөлмөрийн таатай нөхцөлийг бүрдүүлэх чиглэл

- 9.1. Ажилласан жил шаардахгүй ажлын байруудыг олноор бий болгох, ажлын байрны сонгон шалгаруулалтад бодит байдлаас хэтэрсэн шаардлага тавих явдалд мониторинг хийсний үндсэн дээр зохистой хязгаарлалтыг хөдөлмөр нийгмийн зөвшлийн гурван талт хэлэлцээрийн механизмаар дамжуулан хийхийг эрмэлзэнэ.
- 9.2. Залуучуудад ажлын байр шинээр бий болгох, түүнийг тогтвортой байлгахад ажил олгогч нарт шаардлагатай хөшүүргийг бий болгоно.
- 9.3. Оюутан залуучуудын цагийн ажлын тогтолцоог бий болгох, ажил олгогч нарт цагийн ажлыг бий болгох хөшүүргийг бий болгоно.
- 9.4. Залуучуудыг нийгмийн даатгалын цахим карттай болгож, аль болох нийгмийн даатгалд эрт хамруулах хөшүүргийг бий болгоно.
- 9.5. Залуучуудын хөдөлмөрийн бирж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг үндэсний хэмжээний залуучуудын байгууллагатай хамтран тогтвортой ажиллуулна.
- 9.6. Дээд боловсролтой, ахисан түвшний судалгааны ажил эрхэлж байгаа залуу хүмүүст зориулсан цагийн ажлыг бий болгох үүднээс төрийн албанд судалгаа, шинжилгээний чиглэлийн цагийн ажлын квотыг их, дээд сургуулийн докторантурын хөтөлбөрүүдтэй харилцан уялдаатайгаар бий болгоно.
- 9.7. Залуучуудын ажлын байран дахь хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах ажлыг олон улсын стандарт, туршлагын дагуу удирдлага, арга зүйгээр хангаж, ажлын байрны нөхцөл, аюулгүйн техник, хувцас, хэрэгсэл, тоноглолоор хангагдах эрхийг бодитой хангуулна. Энэ чиглэлээр үйлдвэрчний эвлэлийн байгууллагатай хамтран ажиллана.
- 9.8. Залуучуудын хөдөлмөрийн маргааныг богино хугацаанд, хөдөлмөрийн арбитрын үйл ажиллагааг идэвхтэй хэрэглэх замаар хүнд суртал, зардал чирэгдэлгүй шийдвэрлэдэг болгох эрх зүйн орчныг бий болгоно.

9.9. Малчин залуучуудын орлогын тогтвортой байдлын талаар тусгайлсан бодлого, стратегийг тууштай хэрэгжүүлнэ.

Арав. Залуучуудын орон байрны хэрэгцээг хангах төрөл бүрийн шийдлүүдийг бий болгоход дэмжлэг үзүүлэх

10.1. Бага хүүтэй, урт хугацаатай орон сууцны зээлийн эх үүсвэрийг тууштай хэрэгжүүлэх замаар залуу гэр бүлийг орон сууцжуулна.

10.2. Хямд үнэтэй, чанартай, нийгмийн үйлчилгээ, дэд бүтцийг цогцоор нь шийдвэрлэсэн орон сууцны хорооллуудыг барихад аж ахуйн нэгжүүдэд бодит хөшүүрэг бий болгохын зэрэгцээ байгууллага хамт олон, төрийн болон хувийн салбаруудыг хамруулах замаар зохион байгуулж эрэлтийг дэмжинэ.

10.3. Улирлын чанартай ажлын шугамаар түр хугацаагаар гэрээсээ хол амьдарч буй залуучууд, оюутнууд болон хөгжлийн бэрхшээлтэй залуучуудад зориулсан бүрэн тоноглол, тавилга, үйлчилгээ бүхий хямд үнэтэй түрээсийн нийтийн байруудыг олноор барих замаар тэдний орон байрны хэрэгцээг хангана.

10.4. Алслагдсан сум сууринд мэргэжилтэй залуу боловсон хүчин суурьшихад дэмжлэг үзүүлэх орон байр, цэцэрлэг, эрүүл мэндийн үйлчилгээний цогц арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

10.5. Орон гэргүй, нэн ядуу, архи согтууруулах ундаа, сэтгэцэд нөлөөлөх бодис донтсон зэрэг нийгмийн дэмжлэг шаардлагатай залуучуудад сэтгэл засал, эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээ, хордлого тайлах, хооллох зэрэг үйлчилгээ бүхий тусгай зориулалтын байруудыг барьж байгуулах, үйлчилгээг нь төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэрээр шийдвэрлэх асуудлыг олон улсын туршлага, олон улсын байгууллагуудын тусламж, зөвлөгөөнд тулгуурлан бий болгоно.

Арван нэг. Нийгэм дэх залуучуудын эерэг дүр төрхийг бий болгох чиглэл

11.1. Ёс суртахууны эерэг үнэлэмж бүхий, үе тэнгийнхнээ манлайлагч залуучуудын ажил үйлс, амжилтын таниулах агуулга бүхий контентыг төрийн бодлогоор дэмжинэ.

11.2. Монгол залуучуудын оюуны өндөр чадавх, ёс суртахуунлаг, эвсэг чанар зэрэг оновчтой томъёологдсон нийгмийн дүр төрхийг тодорхойлох, цаашид хэвшүүлэх талаар залуучуудын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас үндэсний хэмжээний төрийн бус байгууллагуудтай тууштай хамтран ажиллана.

11.3. Залуучуудын дунд явуулж буй хүмүүжлийн ажилд уламжлалт соёл, ёс заншил, арга зүйн тэргүүлэх ач холбогдлыг харгалзахын зэрэгцээ, тэдний хувь хүний эрхэмсэг оршихуй, даяаршиж буй нийгмийн орчин дахь бусад соёлуудын нөлөөлөл бүхий амьдралын хэв маяг, харилцааны хүрээ (цахим болон бодит) –г хүлээн зөвшөөрнө.

Арван хоёр. Залуучуудын оролцоог дэмжих механизмыг бий болгох чиглэл

12.1. Залуучуудыг бодлого боловсруулалтын идэвхгүй объект биш харин бодлогын бүх түвшинд өөрийгөө илэрхийлэх эрхтэй идэвхтэй субъект хэмээн хүлээн зөвшөөрнө.

12.2. Залуучуудын бодлого, хөтөлбөр, тэдний амьдралд чухал нөлөөтэй аливаа шийдвэрийг гаргах, тийм үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөхөд залуучуудын оролцоог хангах үр дүнтэй механизмыг Засгийн газар бий болгож ажиллана.

12.3. Залуучуудын сонгуулийн идэвх оролцоог сайжруулах талаар судалгаа хийж, үр дүнд хүргэх ажлыг зохион байгуулна.

12.4. Оюутны өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааны санхүүжилтийг шийдвэрлэх, түүнд хяналт тавих, үр ашигтай санал, санаачилгыг дэмжих нь их, дээд болон мэргэжлийн боловсролын байгууллагын удирдлагын багийн ажлын үр дүнг хэмжих чухал үзүүлэлтүүдийн нэг байна.

12.5. Оюутны нийгмийн идэвх, оролцоог кредитжүүлэх замаар нийгмийн ажлын үнэ цэнэ, ач холбогдлыг үнэлэх тогтолцоог бий болгоно.

Арван гурав. Нийгмийн дэмжлэг хэрэгтэй залууст зохистой арга,  
хэлбэрээр хүрч ажиллах

13.1. Хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын талаарх эрх зүйн зохицуулалтыг нийгмийн баталгааг хангах чиглэлээр хязгаарлахгүй улмаар тэдний оролцоо, хөгжлийн хэрэгцээг хангах чиглэлээр олон улсын жишиг, хандлагад нийцүүлэн боловсронгуй болгоно.

13.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний амьдрах, ажиллах, сурах, хөдөлмөрлөх орчны дэд бүтцийг үе шаттайгаар шийдвэрлэнэ. Барилга байгууламж, зам, тээврийн болон нийтийн үйлчилгээний стандартыг тэдний хэрэгцээнд нийцүүлэн боловсронгуй болгон баталж мөрдүүлэх ажлыг зохион байгуулна.

13.3. Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан туслах үйлчилгээний оновчтой тогтолцоог бий болгоно.

13.4. Хорих ял эдэлж буй залуучуудыг дахин нийгэмшүүлэх, гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор сэтгэл зүйн болон иргэний боловсрол олгох, тусгай радио хөтөлбөр боловсруулах хэлбэрээр хүргэнэ.

Арван дөрөв. Залуучуудын байгууллага, залуучууд судлалыг  
тууштай хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх чиглэл

14.1. Залуучуудын оролцоог хангах, залуучуудын бодлого, хөтөлбөрийг боловсруулахдаа залуучуудын байгууллага, залуучуудын салбарын санал, санаачилгад тулгуурлана.

14.2. Засгийн газар, яам, агентлаг, төрийн байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, статистикийн нэгжүүдийг хамруулсан, залуучуудын талаар мэдээлэл цуглуулах тогтвортой стратегийг боловсруулна.

14.3. Залуучуудын байгууллагуудын ил тод, үр ашигтай санхүүжилтийн тогтолцоог бий болгоно.

14.4. Залуучуудын бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтэнд дүн шинжилгээ хийхэд залуучуудын салбарын төрийн бус байгууллагуудыг тэдгээртэй байгуулсан гэрээний үндсэн дээр оролцуулна.

14.5. Залуучууд судлалыг хөгжүүлэх, хамрах шаардлагатай чиглэл, сэдвийн талаар зөвлөлдөх механизмыг бий болгоно. Монголын залуучуудын тайланг хоёр жил тутам гаргана. Энэ тайланг боловсруулахад залуучуудын салбарын байгууллагуудыг оролцуулна.

14.6. Төрөөс залуучууд судлалын тэтгэлэгт хөтөлбөрийг бий болгох замаар залуучууд судлалын үндэсний мэргэшсэн байгууллагууд, судлаачдын залгамж халааг байнга дэмжинэ.

#### Арван тав. Бодлогыг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэр

15.1. Залуучуудын бодлогыг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

15.1.1. Улсын болон орон нутгийн төсөв;

15.1.2. Хувь хүн, хуулийн этгээдээс Монгол Улсын хууль тогтоомжоор хориглоогүй хэлбэрээр олгох хандив, тусламжийн эх үүсвэр;

15.1.3. Энэ бодлогод заасан зорилтуудыг хэрэгжүүлэх чиглэлээр төр, хувийн хэвшлийн түншлэлийн үндсэн дээр хэрэгжүүлэх төслийн санхүүжилт;

15.1.4. Олон Улсын Байгууллага, хандивлагчдын санхүүжилт:

15.2. Төрөөс залуучуудын талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд улсын төсвийн ... ээс доошгүй хувийг зарцуулна.

15.3. Залуучуудын эрүүл мэндийг хамгаалах, тэдний мэдлэг чадварыг дээшлүүлэх, нийгмийн баталгааг сайжруулах зэрэг арга хэмжээг санхүүжүүлэхэд гадаадын хөрөнгө оруулалт, зээл, тусламжийг нэн тэргүүнд зориулна.

15.4. Төрийн үйлчилгээ, халамж төдийлөн хүрдэггүй нийгмийн дэмжлэг шаардлагатай хэсэг зориулсан тусгайлсан үйлчилгээ, тухайлбал, хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй залуучуудад туслах үйлчилгээ, хорих ял эдэлж буй залуучуудад үзүүлэх сэтгэл засал, хүмүүжлийн үйлчилгээг бий болгохдоо төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэрээр мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэхийг дэмжинэ.

15.5. Залуучуудад чиглэсэн үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгж, залуучуудын өөрсдийн оролцоог нэмэгдүүлэх хөрөнгө оруулалт, санхүүжилтийг төрөөс хөхиүлэн дэмжинэ.

#### Арван зургаа. Бодлогын хэрэгжилтийн тухай олон нийтийн сонсгол

16.1. Улсын Их Хурал залуучуудын бодлогын хэрэгжилтийн талаар жил бүр Засгийн газрын сонсголыг олон нийтэд нээлттэй зохион байгуулна.

16.2. Олон нийтийн сонсголд залуучуудын салбарын болон залуучуудын төлөөллийг оролцуулж тодорхой судалгаа, шинжилгээнд үндэслэсэн илтгэлүүдийг хэлэлцүүлнэ.

#### Арван долоо. Бодлогын хяналт, үнэлгээний тогтолцоо

17.1. Залуучуудын бодлого, түүний хүрээн дэх залуучуудын хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр нөлөө, үр ашгийн талаарх хяналт үнэлгээ нь албан ёсны, хөндлөнгийн, сайн дурын гэсэн хэлбэрүүдтэй байна.

17.2. Албан ёсны хяналт нь улсын төсвийн болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг хамарна.



- 17.3. Хөндлөнгийн үнэлгээг нь залуучуудын салбарт үйл ажиллагаа явуулдаг туршлагатай төрийн бус байгууллагуудаар нээлттэй, ил тод сонгон шалгаруулалтын үндсэн дээр гэрээгээр гүйцэтгүүлнэ.
- 17.4. Залуучуудын салбарын төрийн бус байгууллага залуучуудын бодлого, хөтөлбөр, бусад асуудлаар сайн дурын хяналт, үнэлгээ, судалгаа хийж болно.
- 17.5. Төрийн захиргааны бүх шатны байгууллага залуучуудын бодлогын хяналт, үнэлгээ, судалгааны ажилд шаардлагатай, төр, хувь хүн, байгууллагын нууцад хамаарахаас бусад мэдээ баримтыг гаргаж өгөх үүрэгтэй.

----oOo----